



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр, Пүрэв гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-6</i>
<hr/>	
<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/</i>	<i>4-6</i>
<i>2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	<i>6</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 10 дугаар  
сарын 05-ны өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 20 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Энхбаяр.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Б.Баттөмөр танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

**Б.Баттөмөр:** “Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 1

Бүгд: 9

88.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сувдмаа, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга Т.Энхболд нар орж ажиллахаар тогтов.

*Уг асуудлыг 09 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл** /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш байлцав.

Байнгын хорооны дарга Б.Баттөмөр тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Баттөмөр:** “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 10 минут үргэлжилж, 10 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 90.0 хувийн ирцтэйгээр 09 цаг 30 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр,  
Пүрэв гараг Төрийн ордон “Их эзэн  
Чингис хаан” танхим 09 цаг 20 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Баттөмөр:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны гишүүдийн ирц ирсэн ирц бүрдсэн тул Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Ингээд хуралд ирэх гишүүдээс Баттөмөр ирсэн байна. Адъяаа гишүүн ирсэн байна, Баделхан гишүүн ирсэн байна, Бямбацогт гишүүн ирсэн байна, Л.Энх-Амгалан гишүүн ирсэн байна, Нямаагийн Энхболд гишүүн ирсэн байна, Б.Энхбаяр гишүүн алга байна. Энхбаяр гишүүн хуралдаа суугаарай.

Б.Бат-Эрдэнэ гишүүн хуралдаа ороорой, Баярсайхан гишүүн хуралдаан ороорой, Бейсен гишүүн хуралдаа ороорой.

Бейсен ороод ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт нь, Байнгын хорооны тогтоолын төсөлд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай,

Хоёрдугаарт нь, Байнгын хорооны тогтоол /Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай гэсэн ийм 2 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүн алга уу? Алга байна. Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа орёе.

Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье ээ.

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 5 дугаар тогтоолоор тогтоолоор Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмыг баталсан. Энэ журмын дагуу байнгын хорооны 6 дугаар тогтоолоор Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан. Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн даргатай тохиролцсоны дагуу Ёс зүйн байнгын хорооны энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Байнгын хорооны дарга Баттөмөрийн оронд Улсын Их Хурлын гишүүн Байнгын хорооны гишүүн Бейсенийг оруулах саналтай байна. Энэ оруулж байгаа саналтай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Энхболд гишүүн үг хэлье.

**Н.Энхболд:** Баярлалаа.

Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль гарсан. Энэ хуулиар энэ нийт төрийн албан хаагчдын ёс зүйн асуудалд хяналт тавьж байх тодорхой арга хэмжээнүүдийг авч байх, журмууд боловсруулах, түүнийгээ дагаж мөрдүүлэх ажилд хяналт тавьж байх ийм Ёс зүйн хороо гэж бүтэц бий болгох тухай заалт байгаа. Энэний дагуу манай Байнгын хорооноос энэ асуудлыг эрхэлж эхнээс нь зохицуулаад явж байгаа. Энэ Ёс зүйн хороо гэдэг бүтэцэд бол Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдээс гадна тусгайлан гарсан журмын дагуу жишээ нь Их Хурлын Тамгын газар, ХЭҮК, ЗГХЭГ, ТАЗ, АТГ, Хуульчдын холбооны төлөөлүүд орохоор ийм шийдвэртэй. Энэ шийдвэрийн дагуу

бид нар 5 хүн нь бол яг хуулийн дагуу квотоор юм уу, албан тушаалаар ингээд бүрэлдэхүүндээ орчхож байгаа юм. Үлдсэн 4 хүнийг нь орон тооны бус гишүүнийг нь сонгох ёстой. Энийгээ бас нэлээн нарийвчилсан дүрэм журмаар сонсгол хийж байж, танилцаж байж ингэж цаашидаа хийх үйл ажиллагаа нь бас их чухал ач холбогдолтой учраас нэлээн анхаарал тавьж нарийн шалгууруудтай сонгож авах ёстой юм байгаа юм аа.

Энэ орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах энэ ажлын хэсгийг Байнгын хорооны тогтоолоор байгуулсан. Урьд нь бол Улсын Их Хурлын 3 гишүүн миний бие Бат-Эрдэнэ гишүүн, Баттөмөр гишүүн орсон байсан. Бид тэгээд ярьж байгаад сая энэ ажлаа хийх явцад бас энд цөөнхийн төлөөллөөс байх нь зүйтэй юм гэж үзээд энэний түрүүн бид нар хурал хийхэд тэр хурал дээр бас зарим гишүүд маань байгаагүй. Тэгээд ярьж байгаад санал болгоод АН-ын бүлэгтэй Байнгын хороон дарга ярьсан байх. Ингээд Бейсен гишүүнийг оруулаад Баттөмөр гишүүн өөрөө гараад шинээр бүрэлдэхүүнээ томилж байгаа юм. Тэгээд өнөөдөр бид нар ажлын хэсгээ хуралдуулна. Орон тооны бус гишүүд сонгон шалгаруулах зар мэдээгээ бол олон хоногийн өмнө нэлээд олон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дээр тавьчихсан байж байгаа. 4 хүн шалгаруулах ёстой, хүмүүсийн санал ирсэн.

Тэгээд өнөөдөр бид анхны их хурлаа хийгээд цаашидаа яаж асуудлаа үргэлжлүүлээд явах уу гэдгээ шийдэх юм аа. Тийм учраас асуудлаа ингээд ажлын хэсгийнхээ бүрэлдэхүүнийг шинэчилчихвэл 2 цагаас бид нар хуралдах учиртай гэдгийг хэлье

**Б.Баттөмөр:** Энхболд гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх

заалт 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дэх зүйлийн 11.4, 11.5 дахь заалтыг үндэслэн Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооноос тогтоох нь:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль Монгол Улсын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны тогтоолоор баталсан Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 5-д заасныг үндэслэн Ёс зүйн хорооны орон тооны бус 4 гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Нямаагийн Энхболд, Улсын Их Хурлын гишүүн, байнгын хорооны дарга,

Ажлын хэсгийн гишүүдэд Б.Бат-Эрдэнэ гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Бейсен гишүүн,

Энэбиш Ёс зүй, сахилгын хариуцлагын байнгын хорооны ахлах зөвлөх, Адъяахишиг ХЭҮК-ын Тамгын газрын дарга, Сувдмаа ЗГХЭГ-ын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга, Ч.Бат-Эрдэнэ, ТАЗ-ийн Маргаан таслах хянан шалгах газрын дарга, Т.Энхболд АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Жолбарс Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулж байна.

Энэ ажлын хэсэг байгуулсантай холбогдуулан санал хэлэх хүн байна уу? алга байна. Ингээд орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын Ёс зүй сахилгын хариуцлагын байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 88.9 хувийн саналаар батлагдаж байна. Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа.

Ингээд Байнгын хорооны тогтоолыг сая танилцуулчихсан.

Байнгын хорооны хуралдаанаар батлагдсан ажлын хэсэг өнөөдрөөс эхлээд 14 цагт Үндсэн хуулийн танхимд хуралдахаар байгаа. Ажлын алба хуралдааны бэлтгэлийг хангая.

#### 14.27 цагт

Дараагийн асуудлыг хэлэлцье ээ. Энэ асуудал ингээд дуусаж байна. Байнгын хорооны тогтоол 10 дугаар сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглаврыг баталъя.

Байнгын хорооны тогтоолын төсөл. Цаглаврыг гишүүдэд тараасан байгаа. Цаглавартай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 77.8 хувиар санал дэмжигдэж байна аа. Ингээд өнөөдрийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Зарлалын шинж чанартай нэг зүйл байна. Энэ нэг дэх өдөр Монголын нийгэм дэх ёс суртахууны төлөвшил, цаашидын чиг хандлага гэсэн ийм хэлэлцүүлгийг энэ танхимд зохион байгуулах гэж байгаа юм. Энэ их чухал сэдэв байгаа. Энд бол одоо 3 илтгэл тавигдана.

Ёс зүйн өнөөгийн байдал, цаашидын чиг хандлага, тэгээд олон улсын туршилага, энд эрдэмтэд, төр нийгмийн зүтгэлтнүүд, судалгаа хийдэг хүмүүс, шашны байгууллагын төлөөллүүд гээд их олон хүмүүс оролцоно. Энэнээс зөвлөмж гарах юм байгаа юм. Энэ бол Монголын нийгмийн хамгийн тулгамдсан асуудал байж байгаа. Ер нь 30 жилийн хугацаанд яг энэ асуудлаар бид нар дорвитой юм ерөөсөө яриагүй.

Тийм учраас энэ дээр манай Байнгын хорооны гишүүд бас оролцож санал бодлоо хэлж оролцохыг хүсэж байна аа.

Ингээд хуралдаа идэвхтэй оролцсон Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

#### 14.30 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС УРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА